III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,994,963,800.00	3,733,438,378.06
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	186,887,200.00	179,887,200.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	186,887,200.00	179,887,200.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,067,987,300.00	1,007,604,891.46
320001	Орон нутгийн төсвөөс	1,067,987,300.00	1,007,604,891.46
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	194,000,000.00	84,957,971.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	143,000,000.00	83,635,089.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	1,322,882.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	41,000,000.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	43,326,185.99

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	11,263,949.27
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,427.00	1,417.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	8	8
610001	Төсвийн байгууллага	2	2
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	65	66
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	11	12
620003	Үйлчлэх ажилтан	2	2
620004	Гэрээт ажилтан	43	43
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	65	66
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	38	38
650010	Гэрээт ажилтан	9	9
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/ ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	118,406,094.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,620,959.69
210	БАРАА , АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,220,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,120,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,120,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,600,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,400,959.69
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,400,959.69
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	5,538,959.69
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,862,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	103,785,135.00
2200	Дотоод эх үүсвэрээр	103,785,135.00
223001	Бусад хөрөнгө	103,785,135.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	112,867,135.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	112,867,135.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,507,135.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,360,000.00

III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-5,538,959.69
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,538,959.69

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төрийн захиргааны байгууллагын манлайллыг дээшлүүлж, Төрийн албаны шинэчлэлийг гүнзгийрүүлж, хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хөгжлийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 112.7 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 200.3 сая төгрөг болж 87.6 сая төгрөгөөр өссөн байна.

<i>Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл</i>			<i>/сая төгрөг/</i>	
<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Төрийн сангийн харилцах	112.7	200.3	87.6	43.8
Дүн	112.7	200.3	87.6	43.8

Эх сурвалж: Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 200.3 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого 189.1 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 9.1 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сан 2.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Өмнөговь сумын Эрүүл мэндийн төв:

Эрүүл мэндийн төв нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь хэсэгт “Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно” гэж заасныг зөрчин сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй 4 ажилтанд нийт 4.5 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосонд төлбөрийн акт тогтоосон.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 431.5 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 326.0 сая төгрөг болж 105.5 сая төгрөгөөр буурсан байна.

<i>Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл</i>			<i>/сая төгрөг/</i>	
<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.6	0.0	-1.6	

Зээлийн хүүгийн авлага	16.9	19.7	2.8
Төлбөрт үйлчилгээний авлаг	111.7	0.0	-111.7
Байгууллагаас авах авлага	34.6	0.5	-34.1
Хувь хүмүүсээс авах авлага	32.0	32.0	0.0
Зээлийн авлага	234.7	273.8	39.1
Дүн	431.5	326.0	-105.5

Эх сурвалж: Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл буурахад Эрүүл мэндийн төвийн төлбөрт үйлчилгээний санхүүжилт 111.7 сая төгрөгөөр, байгууллагаас авах авлага 34.1 сая төгрөгөөр буурсан нь голчлон нөлөөлжээ. Мөн Хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага өссөн байна.

3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 448.7 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 277.8 сая төгрөг болж 170.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	11.4	0	-11.4
Бичиг хэргийн материал	14.9	2	-12.9
Аж ахуйн материал	158.1	40.8	-117.3
Сэлбэг хэрэгсэл	9.9	1.8	-8.1
Түлш шатах тослох материал	1.1	0	-1.1
Барилгын засварын материал	4.2	0	-4.2
Хүнсний материал	12.5	0	-12.5
Бусад хангамжийн материал	236.6	221.5	-15.1
Мал амьтад	0	11.7	11.7
Дүн	448.7	277.8	-170.9

Эх сурвалж: Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн бууралтад Улсын төсвөөс санхүүждэг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүгийн тайлан харьяа яамдад нэгтгэгддэг болсон нь нөлөөлжээ. Үүнд: Эм боох материал, бичиг хэргийн материал, аж ахуйн материал, хүнсний материал, бусад хангамжийн материал буурсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 12,061.7 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 4,696.7 сая төгрөг болж, 7,365.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	7,957.10	1,187.20	-6,769.90
Хуримтлагдсан элэгдэл	-559.4	-262.50	296.90

Авто тээврийн хэрэгсэл	249.4	108.0	-141.40
Хуримтлагдсан элэгдэл	-173.5	-86.5	87.00
Машин тоног төхөөрөмж (компьютер)	1174.5	241.1	-933.40
Хуримтлагдсан элэгдэл	-751.9	-111.9	640.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	409.2	75.7	-333.50
Хуримтлагдсан элэгдэл	-281.3	-55.7	225.60
Зам, гүүрийн байгууламж	3519.6	3519.6	0.00
Хуримтлагдсан элэгдэл	-245.9	-382.9	-137.00
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	68.8	0	-68.80
Дуусаагүй барилга байгууламж	115.0	115.0	0.00
Номын фонд	57.7	0	-57.70
Бусад үндсэн хөрөнгө	510.1	462.9	-47.20
Хуримтлагдсан элэгдэл	-190.9	-165.7	25.20
Программ хангамж	6.1	2.8	-3.30
Хуримтлагдсан элэгдэл	-3.9	-2.2	1.70
Бусад биет бус хөрөнгө	207.2	58.0	-149.20
Хуримтлагдсан элэгдэл	-6.2	-6.2	0.00
Дүн	12,061.7	4,696.7	-7,365.0

Эх сурвалж: Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,696.7 сая төгрөг болж 7,365.0 сая төгрөгөөр буурахад гүйцэтгэлээр санхүүжих улсын төсөвт байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээс голчлон нөлөөлсөн байна. Тайлант онд шилжүүлэн авсан хөрөнгө 38.0 сая, бусад эх үүсвэрээс 172.9 сая, нийт 210.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, бүтцийн өөрчлөлтөөр 8,675.4 сая төгрөгийн шилжүүлж, 40.0 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 16.6 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 4.0 сая төгрөг болж 12.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өссөн+ Буурсан -</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Ажилчидтай холбоотой өглөг	4.4	0.0008	-4.3992	
Байгууллагад төлөх өглөг	9.7	1.2	-8.5	
Хувь хүмүүст төлөх өглөг	2.5	2.8	0.3	
Татварын өглөг			0	
НДШ өглөг			0	
Нийт дүн	16.6	4.0	-12.6	

Эх сурвалж: Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 4.0 сая төгрөг болж 12.6 сая төгрөгөөр буурсан нь байгууллагад төлөх болон ажилчидтай холбоотой өглөг буурснаас шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

Өмнөговь сумын ИТХ:

Сумын ИТХ тайлант онд олгогдоогүй албан томилолтын зардал 610.0 мянган төгрөгийг өглөгөөр тусгаагүй байсанд санхүүгийн тайланд өглөг тусгуулан залруулга хийлгэсэн.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 13,038.0 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 5,496.8 сая төгрөг болж, 7,541.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

/сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+/ бууралт /-/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	2,894.50	657.60	-2,236.90	
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	6,418.50	4,540.80	-1,877.80	
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	3,725.00	298.40	-3,426.60	
<u>Дүн</u>	13,038.00	5,496.80	-7,541.20	

Эх сурвалж: Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,496.8 сая төгрөг болж 7,541.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 4,540.8 сая төгрөг болж 1,877.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.10 Орлогын данс

Тайлант онд Өмнөговь суманд татварын орлого 400.7 сая, татварын бус орлого 474.1 сая, тусламж санхүүжилтийн орлого 2,068.3 сая, нийт 2,943.1 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Өмнөговь сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн орон нутгийн төсвийн тодотгол батлах тухай 7/01 дугаар тогтоолоор Өмнөговь сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 288.5 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 404.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 115.7 сая төгрөг буюу 140.1 хувиар биелүүлсэн байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,448.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,448.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,448.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,001.8 сая төгрөгийг урсгал зардалд, 272.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 175.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 186.9 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,068.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 143.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 10.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 41.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 179.9 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,007.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 83.6 сая төгрөгийг үндсэн ажиллагааны орлогоос, 1.3 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 1,272.4 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1302.5 сая төгрөг буюу 89.9 хувьтай байгаа нь Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл 58.4 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн гүйцэтгэл 67.9 сая төгрөгөөр дутуу болон 18.6 сая төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчаас 106.5 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6.4 сая, нийт 112.9 сая төгрөгийг төвлөрүүлэн, 108.0 сая төгрөгийг зарцуулж 4.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022

оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 45 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 12.4 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,489.8 сая төгрөгийн 0.5 хувь буюу 12.4 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 9.9 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Өмнөговь сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө 64.4 хувиар давж биелснээс аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/697 дугаар захирамжийн дагуу сумын орон нутгийн давсан орлогоос 70.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн орлогод татаж авсан байна.

Сумын 2022 оны татварын орлогын гүйцэтгэл зарим нэр төрлөөр тасарч, зарим нэр төрлөөр давж, нийт дүнгээр 185.7 сая төгрөгөөр давж биелсэн байна. Иймд төсвийн орлогыг бодитой төлөвлөж байхыг зөвлөмж болголоо.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 153, хугацаа хоцроож 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 санг түүвэрт хамруулсан болно.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 6 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 5.1 сая төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснээс 0.6 сая төгрөгийн 1 алдааг залруулга хийж, 4.5 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ИТХ	1	0.6	1	0.6						
2	ЭМТ	1	4.5			1	4.5				
	Дүн	2	5.1	1	0.6	1	4.5				

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 115.7 сая төгрөгийн 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

Өмнөговь сумын 2022 оны татварын орлогын гүйцэтгэл зарим нэр төрлөөр тасарч, зарим нэр төрлөөр давж, нийт дүнгээр 115.7 сая төгрөгөөр буюу 140.1 хувийн биелэлттэй гарсан байна. Тухайлбал: шууд бус орлогын албан татвар 10.6 сая, малд ногдуулах албан татвар 45.7 сая, хөрөнгийн орлого 5.4 сая, түгээмэл тархацтай ашигт малтмалын татвар 1.7 сая, газрын төлбөр 1.7 сая, бусад орлого 1.5 сая, бууны албан татвар 0.4 сая төгрөгөөр тасарч, ан амьтны нөөц ашигласны төлбөр 177.8 сая, үйл ажиллагааны орлого 2.2 сая, хөрөнгө борлуулсны орлого 6.5 сая, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 1.7 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Өмнөговь сумын 2022 оны татварын орлогын гүйцэтгэл зарим нэр төрлөөр тасарч, зарим нэр төрлөөр давж, нийт дүнгээр 115.7 сая төгрөгөөр давж биелсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт "Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 66.1.1 дэх заалтад "Тухайн шатны төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах", Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт "Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 59.1.7 дахь заалтад "Хууль тогтоомж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 22.1-д заасан асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах", 59.1.19 дэх хэсэгт "Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах" гэж заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ сумын татварын орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

Зөвлөмж:

Сумын татварын орлогыг бодитой төлөвлөж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хангаж, нотлох баримтын хамт 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор манай байгууллагад ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	115.7					1	115.7
Нийт дүн	1	115.7					1	115.7

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Г.НАМЖИЛ/

2023 оны 03 сарын 23-ны өдөр